ДОРНОГОВЬ АЙМАГ
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 05 өдөр Дугаар 15/05 Сайншанд сум

Аймгийн дэд болон зорилтот хөтөлбөрүүдийн 2023 оны биелэлтийг үнэлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.6, 35.1.15, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 11 дэд болон зорилтот хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилт, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэн биелэлтийн дунджийг 87,4 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсүгэй.

2.Аймгийн дэд болон зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэн, бодит үр дүнг бий болгоход анхаарч хэрэгжилтийг жил бүр тайлагнан, үнэлүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нутгийн удирдлагын хөгжлийн хорооны ахлагч (И.Батсүрэн), аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Батсугир) нарт тус тус даалгасугай.

ДАРГА Б.ГАНЗОРИГ

442230131